


Газрын даргын 2024 оны 07 дугаар сарын
22-ны өдрийн А/39 дүгээр тушаалын
13 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ



I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Хот байгуулалт, хотын стандартын
газар

Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн
төлөвлөлтийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэд бүтцийн төлөвлөлтийн эдийн
засагч

ТҮ-7

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын
зам 1200, Нийслэлийн Нутгийн Захиргааны
цогцолбор барилга

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хот байгуулалтын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд, барилга, байгууламжийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний төлөвлөлтийн эдийн засгийн тооцоо судалгаа боловсруулах, хяналт тавьж гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцан тайлагнана.

<u>Албан тушаалын зорилт:</u> 1.Инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний төлөвлөлтийн төслийн эдийн засгийн тооцоо судалгаа боловсруулах, хяналт тавих, хөрөнгө оруулалтын тооцоо боловсруулан төсвийн төсөлд санал хүргүүлэх. 2.Нэгжийн үйл ажиллагаанд оролцож, дэмжлэг үзүүлэх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх. 3.Хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.			
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн нийслэлийн хэмжээнд шинээр барих инженерийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэгтгэн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэх, холбогдох байгууллагуудад хүргүүлэх.	Инженерийн дэд бүтцийн хөрөнгө тухайн жилийн төсөвт тусгагдсан байна.	Г
	2.Шинээр баригдах хороолол, хотхоныг инженерийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын тооцоог үе шаттай гарган тухайн оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж хүргүүлэх ажлыг зохион байгуулах;	Инженерийн дэд бүтцийн хөрөнгө тухайн жилийн төсөвт тусгагдсан байна	Г
	3. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд инженерийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гарган төсвийн төсөлд санал хүргүүлж шийдвэрлүүлэх;	Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажлын хөрөнгө батлагдсан байна	Г
	4.Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ХЕТ, төсөл хөтөлбөр, техник, эдийн засгийн	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ХЕТ, төсөл хөтөлбөр, ТЭЗҮ батлагдсан байна	Г

	үндэслэлд санал өгч, хэрэгжилтийг ханган ажиллах;		
	5.Гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх зорилгоор батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын тооцоог боловсруулан, хэрэгжүүлэхтэй холбоотой саналыг холбогдох газарт хүргүүлж ажиллах;	Хөрөнгө оруулалтын санал тугагдсан байна	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	Шугам сүлжээний шийдэл, ажлын тоо хэмжээ, үнэлгээг тухайн жилийн үнийн өсөлттэй уялдуулан хянаж харъяа байгууллагуудад санал хүргүүлэх;	Жишиг үнэлгээ баталгаажсан байна.	Г
	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг тайлагнаж ажиллах	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан байна	Г
	Тогтоол шийдвэр, удирдлагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж тайлагнаж ажиллах	Тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн албаны тухай хууль болон төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм журам, байгууллагын дотоод журам, бусад төрийн албаны стандартыг мөрдөж хэрэгжүүлэх;	Төрийн албаны тухай хууль болон бусад стандарт дүрэм, журмыг зөрчөөгүйг нотлох дүгнэлт гаргасан байна.	Г
	2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон Авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдөх, хэрэгжилтийг хангах;	Эрх бүхий албан тушаалтанд ХАСХОМ-ийг өгсөн байдал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.	Г
	3.Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж бүрдүүлэх, байгууллага, нэгжийн өдөр тутмын дотоод үйл	Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байх.	Г

	ажиллагаанд оролцох, зохион байгуулах.		
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	- Эдийн засаг /031101/; - Инженерчлэл, эдийн засаг /048803/.		
Мэргэшил	Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх		
Туршлага	Мэргэжлээрээ ажилласан байх.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг нэгтгэн дүгнэх, санал зөвлөмж боловсруулах; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - тоон судалгаанд үндэслэн харьцуулалт, шинжилгээ хийх; - тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдал, хувилбарыг тодорхойлох чадвартай байх; - бусад.	
	Асуудал шийдвэрлэх	- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - асуудлыг хууль журам, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - албан тушаалын чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - албан үүргээ гүйцэтгэх явцад гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.	
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлдаг байх; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - маргаантай асуудалд хүлээцтэй ханддаг байх; - багийн амжилтыг дэмжиж бусдад таниулах; - бүтээлч санаачилгатай ажиллах; - бусад.	
	Бусад	- AutoCAD, ArcGIS зэрэг программ эзэмшсэн байх; - инженерийн дэд бүтцийн ажлын зураг төсөл боловсруулах, хянах чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн орчин үеийн технологи ашиглах, мэдээллийг шуурхай солилцох; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээлэл өгөх чадвартай байх;	

		- хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх; - байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх.
--	--	--

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дарга.

Албан тушаалд шууд харьяалан

удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

- нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох албан тушаалтан;
- төрийн болон төрийн бус байгууллага;
- иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

..... (Д.ДАШЦЭЦЭГ)
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2024 оны 07 дугаар сарын 22-ны өдөр

Албан тушаал

ДАРГА
(тамга/тэмдэг)

..... (Г.БАТЗОРИГ)
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2024 оны 07 дугаар сарын 22-ны өдөр